



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019

5-Р САР

Э-сонин

70-р дугаар






Зах зээлийн тойм


/2019.05.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	23
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	16,009,769,460.60
Хувьцаа /анхдагч/	8,585,858,960.00
Хувьцаа /хоёрдогч/	5,364,580,060.60
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	2,059,330,440.00
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	143,584,719
Хувьцаа /анхдагч/	122,655,128
Хувьцаа /хоёрдогч/	20,909,013
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	20,578
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	8,631


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	171
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	61
Үүнээс: Брокер, Дилер	52
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.05.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Голомт Капитал ХХК	96,888,687	1,317,033,015	6,135,364	9,702,880,345	17,802,121,449
2	Тэнгэр капитал ХХК	63,970	2,000,749,088	36,698	2,008,305,714	4,012,132,702
3	Апекс Капитал ХХК	367,264	2,316,896,641	150,224	79,079,526	2,421,684,647
4	Лайфтайм инвестмент ХХК	264,548	23,699,460	413,266	2,222,883,372	2,265,101,192
5	Ард секьюритиз ХХК	4,532,710	202,321,394	1,053,919	213,520,554	733,131,648
6	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	1,077,699	280,410,310	4,265,547	328,437,105	684,275,425
7	Бумбат-Алтай ХХК	4,430,212	100,456,103	1,556,426	209,057,062	619,628,005
8	Масдак ХХК	132,691	264,238,418	1,734,208	268,439,670	541,966,458
9	БиДиСек ХК	3,693,067	111,341,040	501,444	131,287,613	501,136,344
10	Ти Ди Би Капитал ХХК	2,046,056	223,992,801	736,029	95,569,427	462,786,148
11	Стандарт инвестмент ХХК	1,812,099	136,444,707	752,953	153,043,163	416,334,801
12	Гаули ХХК	908,425	112,998,694	579,218	106,596,563	283,185,007
13	Гүүдсек ХХК	2,258,943	21,140,831	155,117	14,346,103	193,612,944
14	Ард капитал групп ХХК	485,376	36,003,832	1,346,495	110,062,058	180,042,210
15	Дархан брокер ХХК	117,371	81,558,825	27,750	86,686,275	176,461,070
16	Новел инвестмент ХХК	576,196	52,100,544	202,254	52,227,180	144,639,605
17	Батс ХХК	598,141	4,304,450	555,619	61,699,217	107,873,537
18	Зэргэд ХХК	404,607	23,784,270	173,342	22,114,498	74,221,258
19	Монсек ХХК	203,066	21,387,568	92,358	22,364,724	57,966,912
20	Хүннү Эмпайр ХХК	581,508	2,400,313	97,255	13,989,291	57,095,163

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.05.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	MBG	МОН-ИТ БУЛИГААР	346,385	2,216,930,000	7,500	6,618	-11.76
2	TUM	ТҮМЭН ШУВУУТ	4,769,378	949,877,046	200	166	-15.72
3	MFC	МОНОС ХҮНС	5215735	368307244.3	73	68	2.91
4	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	4565074	300192200.2	67	60.02	-6.53
5	DBL	ДАВААНБУЛАГ	1,729,068	262,393,740	190	169	-13.80
6	APU	АПУ	402,879	234,514,633	596	560	-3.39
7	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	33,754	184,315,580	5,800	5,200	-1.13
8	GOV	ГОВЬ	599,352	172,198,726	298	275	-2.50
9	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	1,931,309	136,256,762	77	65	-4.19
10	TTL	ТАВАН ТОЛГОЙ	14,229	92,602,980	6,950	6,170	4.76
11	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ ХК	350,781	88,900,998	276	237	8.65
12	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	6625	79498300	12000	10300	-13.37
13	AIC	АРД ДААТГАЛ ХК	98,303	65,261,656	684	600	-8.15
14	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	59825	31833772	590	530	-8.50
15	JIV	ЖИНСТ-УВС	11,848	22,816,632	2,100	1,900	-4.40
16	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	27791	19824881.9	790	680	4.50
17	SUU	СҮҮ	96,897	19,482,301	211	195	-5.60
18	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	166	16,738,800	108,000	100,000	-8.73
19	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	24,177	12,152,955	540	455	8.70
20	RMC	РЕМИКОН	312,014	8,812,306	30	27	3.57



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт %/
			2019-05-01	2019-05-31		
1	ХӨХ ГАН	33,110	75.00	88.00	13.00	17.33
2	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	350	165.00	189.75	24.75	15.00
3	ТАВ	10	12,070.00	13,500.00	1,430.00	11.85
4	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	455	405.00	450.00	45.00	11.11
5	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	24,177	460.00	500.00	40.00	8.70
6	МОНГОЛ БАЗАЛЫТ ХК	350,781	248.50	270.00	21.50	8.65
7	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	146	27,500.00	28,900.00	1,400.00	5.09
8	ТАВАН ТОЛГОЙ	14,229	6,300.00	6,600.00	300.00	4.76
9	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	27,791	750.00	783.78	33.78	4.50
10	МЕРЕКС	5,140	26.00	27.00	1.00	3.85
11	МАХИМПЕКС	1,229	2,502.00	2,595.00	93.00	3.72
12	РЕМИКОН	312,014	28.00	29.00	1.00	3.57
13	МОНОС ХҮНС	5,215,735	70.00	72.04	2.04	2.91
14	ШИВЭЭ ОВОО	1,202	1,801.00	1,850.00	49.00	2.72
15	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НӨГДЭЛ	64,030	131.75	135.00	3.25	2.47
16	ТАЛХ ЧИХЭР	432	17,400.00	17,800.00	400.00	2.30
17	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	400	92.00	94.00	2.00	2.17
18	ТЕХНИК ИМПОРТ	37	13,800.00	14,000.00	200.00	1.45
19	УЛААНБААТАР ХИВС	3	15,300.00	15,500.00	200.00	1.31
20	Е-МОНИЕ	30	92.00	92.00	0.00	0.00

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2019-05-01	2019-05-31		
1	ӨНДӨРХААН	37	8,000.00	3,660.00	-4,340.00	-54.25
2	НАКО ТҮЛШ	1,328	97.75	80.00	-17.75	-18.16
3	ТҮМЭН ШУВУУТ	4,769,378	200.00	168.56	-31.44	-15.72
4	АВТО ИМПЕКС	74	2,600.00	2,220.00	-380.00	-14.62
5	УВС ЧАЦАРГАНА	5	448.31	385.00	-63.31	-14.12
6	ОЛЮО	990	79.00	68.00	-11.00	-13.92
7	БАЯНТЭЭГ	80	24,000.00	20,660.00	-3,340.00	-13.92
8	ДАВААНБУЛАГ	1,729,068	198.37	171.00	-27.37	-13.80
9	ГЕРМЕС ЦЕНТР	8,316	133.10	115.00	-18.10	-13.60
10	ТЭЭВЭР ДАРХАН	6,625	11,890.00	10,300.00	-1,590.00	-13.37
11	МОНГОЛ ШИЛТГЭЭН	1,329	400.00	350.00	-50.00	-12.50
12	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	100	250.00	220.00	-30.00	-12.00
13	МОН-ИТ БУЛИГААР	346,385	8,500.00	7,500.00	-1,000.00	-11.76
14	АРИГ ГАЛ	535	3,600.00	3,200.00	-400.00	-11.11
15	НОЁТ ХАЙРХАН	31	478.00	425.00	-53.00	-11.09



“МОНОС ХҮНС” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА НИЙЛҮҮЛТЭЭСЭЭ ДАВЖ ХААГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн эрүүл мэндийн салбарын анхны IPO болох “Монос Хүнс” ХК нь нийт хувьцааны 30 хувь буюу 122,655,128 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2019 оны 4 дүгээр сарын 22-ноос 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 10:00-17:00 цаг хүртэл авч дууслаа.

“Монос Хүнс” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 3,976 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 87,982,368 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 21.7 хувиар давсан үзүүлэлт боллоо.

СЗХ-ны даргын 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 1/2033 тоот албан тушаалаар “Монос Хүнс” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан хоёрдогч зах зээлийн арилжаа эхэллээ.

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБОГДУУЛАН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Инвекор ББСБ” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, “Инвекор ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Анхболд, “Инвекор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан, “Ти Ди Би капитал УЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Батчимэг, “Инвекор Капитал УЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянгахишиг нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 5,978 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

“Инвекор ББСБ” ХК нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулсан 3-р самбарт бүртгэгдсэн бөгөөд энэхүү самбарт бүртгэгдсэн үнэт цаасны арилжаанд өмнө нь олон нийт түлхүү оролцдог байсан бол тус компани нь санал болгож буй нийт хувьцааныхаа 85 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох замаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог хангаж буйгаараа онцлогтой юм.

“Инвекор ББСБ” нь 2019 онд финтект суурилсан бичил зээлийн аппликэйшн, цахим хэтэвч, мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг холбосон шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байгаа төдийгүй, цаашид Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улсуудад үйл ажиллагаагаа тэлэх зорилготой ажиллаж байгаа тухай үнэт цаасны танилцуулгандаа дурджээ. цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА НИЙЛҮҮЛТЭЭСЭЭ ДАВЖ ХААГДЛАА

“Инвекор ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад нийт 336 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож нийт 2,899,735,069 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх доод дүнгээс 15.9 хувь давсан үзүүлэлт боллоо. Харин стратегийн 14 хөрөнгө оруулагчдаас нийт 16,004,292,500 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх доод дүнгээс 6.1 хувь давсан байна.

“Инвекор ББСБ” ХК нь шинээр гаргасан 1.6 сая ширхэг үнэт цаасыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын захиалга бүртгэлийн аргыг ашиглан стратегийн хөрөнгө оруулагчдад 1650-1750 төгрөгийн хооронд, олон нийтэд 1550-1650 төгрөгийн хооронд санал болгосон бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга 100 хувь биелж хуваарилалтыг хийсэн бол олон нийтэд нийлүүлэх нэгж хувьцааны үнийг 1600 төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэлээ. Тогтоосон ханшинаас доогуур захиалга өгсөн хөрөнгө оруулагчдын захиалга биелэх боломжгүй бөгөөд 1600 төгрөгөөс дээш өгсөн захиалгыг журмын дагуу 90.84 хувиар хувь тэнцүүлэн тооцож хуваарилалт хийнэ.

“ЖИНСТ УВС” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 102 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 3-р ангилалд бүртгэлтэй “Жинст-Увс” ХК-д “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-ийг нэгтгэхийг зөвшөөрсөн бөгөөд “Үнэт цаасны төдлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д өмчлөх эрхийн бүртгэл хийхтэй холбоотойгоор СЗХ-ны Улсын байцаагчийн 29 тоот албан шаардлагын дагуу “Жинст-Увс” ХК-ийн үнэт цаасны арилжааг зогсоолоо.

“ТАВАН ТОЛГОЙ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

“Таван толгой” ХК нь 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №04 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 853 төгрөг буюу нийт 44.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөр гаргаж, ногдол ашгийг компанийн байранд болон “ҮЦТХТ” ТӨХХК дэх хувьцаа эзэмшигчдийн дансанд 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн дотор шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.



"АРИГ ГАЛ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

"Ариг гал" ХК нь 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 06/19 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 32.49 төгрөг буюу нийт 109.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоож, 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан тараахаар шийдвэрлэсэн байна.

"БАЯЛАГ НАЛАЙХ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн тухай хуулийн 23, 83.1 дүгээр зүйл, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23.1, "Баялаг Налайх" ХК-ийн 12/2018 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гаргасан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/39 тоот тушаалаар "Баялаг Налайх" (MSE:BNB) ХК-ийн гаргасан 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 311,872 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хасч, арилжааг зогсоолоо.

Тус компанийн үнэт цаасыг биржийн үнэт цаасны бүртгэлээс хассан тухай холбогдох бичиг баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн бөгөөд Хорооны бүртгэлээс хасагдсан тохиолдолд "Баялаг Налайх" хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ болно.

"МОН-ИТ БУЛИГААР" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ЗАРЛАГДЛАА

"Мон-Ит Булигаар" ХК-ийн хяналтын багцыг нэгдмэл сонирхолтой этгээдүүд худалдан авсан тул ҮЦЗЗТ хуулийн 22 дахь заалтын дагуу бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах тендер санал гаргалаа.

Санал болгож буй үнэ: 7,532 төгрөг

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 86.53 хувь

Худалдан авах тоо ширхэг: 53,887 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, АШН-ын хашаа, "Мон-Ит Булигаар" ХК-ийн байр

Дэлгэрэнгүй мэдээллийг 75107500 утсаар авна уу.

ЗАРИМ ГИШҮҮН КОМПАНИУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЗХ-НООС ТҮДГЭЛЗҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 79 тоот тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай дараах нэр бүхий 13 компанийн дилерийн болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн байна. Үүнд:

№	Компанийн нэр	Тусгай зөвшөөрлийн
1	"Асе энд Т Капитал ҮЦК" ХХК	Дилер, андеррайтер
2	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Дилер, андеррайтер
3	"Монсек ҮЦК" ХХК	Дилер, андеррайтер
4	"Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК	Андеррайтер
5	"Эм Ай Би Жи ҮЦК" ХХК	Андеррайтер
6	"Эм Ай Си Си ҮЦК" ХХК	Андеррайтер
7	"Эф Си Икс ҮЦК" ХХК	Андеррайтер
8	"Блюскай секьюритиз ҮЦК" ХХК	Дилер
9	"Гацуурт трейд ҮЦК" ХХК	Дилер
10	"Батс ҮЦК" ХХК	Дилер
11	"Зэт Жи Би ҮЦК" ХХК	Дилер
12	"Өндөрхаан инвест ҮЦК" ХХК	Дилер
13	"Масдак ҮЦК" ХХК	Дилер

ЗАРИМ ГИШҮҮН КОМПАНИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 80 тоот тогтоолоор тусгай зөвшөөрлийн шалгуурыг хангахгүй болсон, зөрчил гаргасан "Аргай бэст ҮЦК" ХХК, "Алтан хоромсог ҮЦК" ХХК болон "Блэкстоун интернэйшнл ҮЦК" ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах эрхийг 3 сараар түдгэлзүүлсэн байна.

Үүнтэй холбогдуулан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/33 тоот тушаалаар дээрх гишүүн компаниудын үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлалаа.

"ФРОНТИЕР ҮЦК" ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Монголын хөрөнгийн биржийн гишүүн "Фронтинер ҮЦК" ХХК нь брокер, дилерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 81 тоот тогтоолоор үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.



“БАЯЛАГ СҮМБЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Баялаг Сүмбэр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 19/5-2 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах тов: 2019.07.01-ний өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2019.06.06-ны өдөр

Хуралдах газар: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоот

Хурлаар хэлэлцэх асуудал:

Компанийн оноосон нэрийг “Global life technology” болгон өөрчлөх

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулан, шинэчлэн найруулах

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах

Бусад

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд саналаа 2019 оны 6 сарын 28-ны өдрийн 17:00 цагаас өмнө компанийн байранд ирүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчид санал авах хуудас болон хурлын материалтай танилцахдаа компанийн байранд 2019 оны 5 сарын 23-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирнэ үү.

Хурал зохион байгуулах комисс: 99069693

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN